



## ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ТОГТООЛ

2024 оны 03 сарын 06 өдөр

Дугаар 106

Улаанбаатар хот

### Шалгалтын мөрөөр авах арга хэмжээний тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 1, 2, 66 дугаар зүйлийн 3, 4 дэх хэсгийг тус тус үндэслэн “Диспетчерийн үндэсний төв” төрийн өмчит хязгаарлагдмал хариуцлагатай компанийн 2021, 2022 оны санхүү, эдийн засгийн үйл ажиллагаанд хийсэн баримтын шалгалтаар нийт 225,238,493.0 (хоёр зуун хорин таван сая хоёр зуун гучин найман мянга дөрвөн зуун ерэн гурван) төгрөгийн зөрчил дутагдал илэрснийг тэмдэглээд ТОГТООХ нь:

1. “Диспетчерийн үндэсний төв” төрийн өмчит хязгаарлагдмал хариуцлагатай компанийн 2021, 2022 оны санхүү, эдийн засгийн үйл ажиллагаанд хийсэн баримтын шалгалтаар илэрсэн зөрчил, дутагдлыг арилгах арга хэмжээний жагсаалтыг хавсралтаар баталсугай.

2. “Диспетчерийн үндэсний төв” төрийн өмчит хязгаарлагдмал хариуцлагатай компанийн Төлөөлөн удирдах зөвлөлд дараах арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай.

2.1. Гүйцэтгэх захиралтай байгуулсан Онцгой нөхцөл бүхий хөдөлмөрийн гэрээний салшгүй хэсэг болох техник, эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшинг заалт бүрээр ханган ажиллах, төлөвлөлтийг сайжруулах;

2.2. Компанийн худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, тайлан болон гэрээний гүйцэтгэлд хяналт тавьж ажиллах;

2.3. Шалгалтаар илэрсэн зөрчил, дутагдлыг арилгах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлтэд хяналт тавьж ажиллах.

3. “Диспетчерийн үндэсний төв” төрийн өмчит хязгаарлагдмал хариуцлагатай компанийн Гүйцэтгэх захирал (Г.Балжинням)-д Төрийн өмчийг эзэмшүүлэх гэрээний 4.2. дахь заалтын хэрэгжилтийг хангаж ажиллах, санхүүгийн сахилга батыг хэвшүүлэн дотоод хяналтыг сайжруулж, дор дурдсан арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг даалгасугай:

3.1. Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журмыг шинэчлэн батлах тухай” 271 дүгээр тогтоол, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2022 оны “Төрийн өмчит хуулийн этгээдийн өмч хамгаалах

Байнгын зөвлөлийн үйл ажиллагааны журам батлах тухай” 65 дугаар тогтоол болон түүний нэмэлт, өөрчлөлтийг мөрдлөг болгон ажиллах;

3.2.Эзэмших эрхийн газрыг үнэлж, санхүү тайланд тусгахдаа Төрийн өмчийн асуудал эрхэлсэн газраас тухай бүр зөвшөөрөл авч байх;

3.3. Компанийн горимын тооцоо болон захиалагчийн хяналтаас олсон орлогын бүртгэлийг сайжруулах, орлого зардлын тооцоог нарийвчлан тооцож байх;

3.4.Үнэлгээний хороонд ажиллаж буй компанийн албан хаагчдыг чадавхжуулах талаар холбогдох арга хэмжээ авч ажиллах, хууль тогтоомж, журмыг зөрчихгүй байх талаар сануулах;

3.5.Тендерт шалгарсан хуулийн этгээдэд урьдчилгаа төлбөр олгохгүй байх, олгосон тохиолдолд Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 43 дугаар зүйлийг мөрдөж ажиллах;

3.6.Засгийн газрын 2015 оны 483 дугаар тогтоолоор баталсан “Дотоод аудитын дүрэм”-ийн 5.1.2 дахь хэсэгт заасан “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгийн хадгалалт, хамгаалалт, бүртгэл, ашиглалт, зарцуулалтын байдалд” дотоод аудит, санхүүгийн хяналт шалгалтыг хийх;

3.7.Худалдан авах ажиллагаанд Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль болон Сангийн сайдын 2023 оны А/250 дугаар тушаалаар баталсан холбогдох журам, зааврыг мөрдөж ажиллах, төлөвлөгөөнд тусгагдаагүй бараа, ажил, үйлчилгээ худалдан авахгүй байх, техникийн тодорхойлолтод компанийн техникийн үзүүлэлтэд тохирсон шаардлага болон тоо хэмжээг тусгаж байх;

3.8.Шалгалтаар илэрсэн зөрчил, дутагдлыг арилгах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлтийг 2024 оны 2 дугаар улиралд багтаан Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлэх.

4.Энэхүү тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн хяналт шалгалтын хэлтэс (Ц.Түвшинзаяа)-т даалгасугай.

ДАРГА


Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН  
ХЭЛТСИЙН ДАРГА

Ц.ТҮВШИНЗАЯА



Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2024 оны 03 дугаар сарын 06-ны өдрийн 106 дугаар тогтоолын хавсралт



**“ДИСПЕТЧЕРИЙН ҮНДЭСНИЙ ТӨВ” ТӨРИЙН ӨМЧИТ ХЯЗГААРЛАГДМАЛ ХАРИУЦЛАГАТАЙ КОМПАНИД ХИЙСЭН ШАЛГАЛТААР ИЛЭРСЭН ЗӨРЧИЛ, ДУТАГДАЛ, ТҮҮНИЙГ АРИЛГАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ЖАГСААЛТ**

Д/д	Зөрчил дутагдлын утга	Мөнгөн дүн /төгрөг/	Авч хэрэгжүүлэх арга хэмжээний санал
1	Эзэмших эрхийн газрыг үнэлж, санхүүгийн тайланд тусгахдаа Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газраас зөвшөөрөл аваагүй.	137,222,400.00, 1021 м.кв талбай бүхий газар	Засгийн газрын 2020 оны 10 дугаар тогтоолыг мөрдөж ажиллах, Төрийн бодлого, зохицуулалтын газрын 2020 оны А-1/1891 дүгээр албан бичгийг хэрэгжүүлэх
2	Төлөвлөгөөнд тусгаагүй үйлчилгээ худалдан авсан.	88,016,093.00	Онцгой нөхцөл бүхий хөдөлмөрийн гэрээ, Төрийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль, Сангийн сайдын 2023 оны А/250 дугаар тушаалаар батлагдсан журмыг мөрдөж ажиллах.
<b>ХЯНАЛТ ШАЛГАЛТААР ИЛЭРСЭН ЗӨРЧЛИЙН НИЙТ ДҮН:</b>		<b>225,238,493.00 (хоёр зуун хорин таван сая хоёр зуун гучин найман мянга дөрвөн зуун ерэн гурван), 1,021 (нэг мянга хорин нэгэн) м.кв талбай бүхий газар</b>	